



NEAR 2016-Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал

NEAR Working-level Workshop 2016

April 27(Wed.) - 29(Fri.), 2016





NEAR 2016-Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал

NEAR Working-level Workshop 2016

April 27(Wed.) - 29(Fri.), 2016





МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцаана уу?

Монгол, Орос, Хятад, Япон, Солонгос улсын хүндэт зочид төлөөлөгчид өө!

Өөрийн үнэт цагаа харамгүй зориулж энэхүү арга хэмжээнд хүрэлцэн ирсэн Пухан хотын захирагч Ли Ган Дог болон өнөөдрийн арга хэмжээг зохион байгуулахад харамгүй дэмжлэг үзүүлсэн Пухан хотын захиргааны холбогдох хүмүүст талархал илэрхийлье.

Хаврын урин дулаан орж буй дөрөвдүгээр сард дэлхийд нэртэй төмөрлөгийн аж үйлдвэрийн хот болох Пуханд Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурлыг зохион байгуулах болсондоо их баяртай байна.

Гишүүн орон нутгуудын төлөөлөгчид өө!

2016 онд тус холбоо байгуулагдсаны 20 жилийн ой тохиож байна. Хүнтэй зүйрлэвэл хэдийнээ нас бие гүйцжээ. 1996 онд Холбоо байгуулагдах үед 4 улсын 29 орон нутаг гишүүнээр элсч байсан бол өдгөө 6 улсын 73 нутгийг гишүүнээр эгнээндээ нэгтгэсэн, орон нутгийн чанартай олон улсын байгууллага болжээ. Энэ нь гишүүн орон нутгуудын идэвх, хамтын ажиллагааны үр дүн гэж бодож байна.

Нөхөд өө!

Байгуулагдаад 20 жилийн ойтой золгож буй тус холбоо одоо нэг шаг ахих шаардлагатай байна. Олон улсын нөхцөл байдал, бүсийн улс төрийн байдал 20 жилийн өмнөхөөс их өөрчлөгджээ. Тиймээс тус холбоо ч шинэ орчин нөхцөлд тааруулж, үндсэн дүрэмдээ өөрчлөлт хийх, мөн гишүүний татвар төлөх журмыг нэвтрүүлэх, Холбооны Хэрэг эрхлэх газрын чадавхийг бэхжүүлэх зэрэг ажлуудыг нэн тэргүүнд хийх шаардлагатай байна.

Мөн цаашид тус Холбооны үйл ажиллагааг амжилттай явуулахад 14 салбар хорооныхоо үйл ажиллагааг идэвхжүүлэх хэрэгтэй. Зөвхөн хурал, арга хэмжээ зохиох бус хороодоор дамжуулж орон нутгууд бодит харилцаа, хамтын ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэх ёстой. Хүүхэд залуучуудад чиглэсэн үйл ажиллагааг явуулахад анхаарах хэрэгтэй байна. Хүүхэд залуучуудыг хоорондоо харилцахад манай холбооны зүгээс их үүрэг гүйцэтгэх ёстой гэж бодож байна.

Үүний тулд ирэх 9 дүгээр сард зохиогдох Бүгд хуралд гишүүн орон нутгийн удирдах дээд албан тушаалтнууд өргөнөөр оролцон, хэрэгтэй санаа өгөхийг хүлээж байна гэдгийг энд хүрэлцэн ирсэн та бүхэн нутагтаа очоод дарга нартаа уламжилж өгнө үү.

Гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүд ээ!

Тус Холбооны үйл ажиллагааг хөгжүүлэхэд та бүхний үүрэг цаашид улам чухлаар тавигдана гэж бодож байна. Та бүхний идэвх, оролцоо, бүтээлч сэтгэлгээ тус холбооны ирээдүйг бүтээхэд хөрс нь болох юм. Холбооны Хэрэг эрхлэх газраас та бүхний санал сэтгэгдлийг үргэлж сонсч, үйл ажиллагаандаа тусгахад анхаарах болно.

Төгсгөлд нь хуралд хүрэлцэн ирсэн та бүхэндээ дахин талархал илэрхийлье. Пухан хотод тавтай морилж, тухлан саатна уу. Бүгдэд нь эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөе.

ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга **Жон Жэ Вон**

CONTENTS [ДАРГААЛАЛ]

Арга хэмжээний тойм	8
• Ерөнхий зүйл / Хөтөлбөр / Суух дараалал	
NEAR Холбооны Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны тайлан	12
• 2015 оны ажлын тайлан, 2016 оны ажлын төлөвлөгөө	
• Салбар хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх тухай ажлын тайлан	
Орон нутгуудын илтгэл	30
• Япон улс	
- Тояама муж(Байгаль орчны хорооны тайлан)	
- Хёго муж(Гамшгаас сэргийлэх хорооны тайлан)	
- Шиманэ муж(Боловсрол, соёлын харилцааны хорооны тайлан)	
• БНСУ	
- Дэжон хот(Иргэн төвт Дэжон хотын танилцуулга)	
- Жолланам муж(“Дэлхийн байгальд ээлтэй дизайны үзэсгэлэн”-гийн танилцуулга)	
• ОХУ	
- Иркутск муж(Иркутск мужид хөрөнгө оруулалт хийхийн давуу талууд, боломжийн тухай	
Гишүүний татварын журам болон Холбооны Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах(Төслийн санал) талаар хэлэлцэх асуудал	56
• Гишүүний татвар төлөх журам(Төслийн санал)	
• Холбооны үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах(Төслийн санал)	
NEAR Холбооноос 2016 онд зохион явуулах арга хэмжээ	66
Хуралд оролцогчдийн нэрс	68



www.neargov.org

Нэг Зүүн хойд Ази, хамтын хөгжлийг манлайлагч- NEAR
One Northeast Asia, NEAR leading co-prosperity

Арга ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

Ерөнхий зүйл
Хөтөлбөр
Суух дараалал





NEAR 2016-Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал

□ Ерөнхий зүйл

- **Хугацаа** : 2016. 4. 27-4. 29
- **Болох газар** : БНСУ-ын Кёнсанбүг мужийн Пухан хот (Бест Вестерн зочид буудал)
- **Хуралд оролцогчид** : 74 оролцогч(5 улсын 39 орон нутаг *Үүнээс гадна Холбооны Хэрэг эрхлэх газрын 17 ажилтан

Улс	Орон нутаг	Оролцогч
Нийт	39	74
Хятад	8	14
Япон	4	10
Солонгос	13	25
Монгол	12	22
Орос	2	4

○ ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газар

○ Гол агуулга

- Холбооны Хэрэг эрхлэх газрын 2015 оны үйл ажиллагаа болон 2016 оны ажлын тайлан
- Гишүүн орон нутгуудын танилцуулга, арга хэмжээний зар, Салбар хороодын үйл ажиллагааны тайлан
- Хэлэлцүүлэг(Гишүүний татвар төлөх журам нэвтрүүлэх, Холбоонд сурвалжлагч гишүүн элсүүлэх гм)
- Соёл аж үйлдвэрийн газартай танилцах аялал (Кёнжү хот дахь “Яндун” тосгон, “Поско” төмөрлөгийн үйлдвэр)

□ Хөтөлбөр

	цаг	агуулга	
4.27	~18:00	Бүртгэл	BEST WESTERN Pohang Hotel
	18:00~21:00	Оройн хоол	буудалд
4.28	07:00~08:30	Өглөөний хоол	буудалд
	09:00~09:20	Хурлын бүртгэл	Буудлын 6 давхарт, Patio танхим
	09:20~09:30	NEAR Холбооны видео танилцуулга үзэх	
	09:30~09:40	Хуралд ирсэн зочид төлөөлөгчдийг танилцуулах	
	09:40~09:45	Мэндчилгээ	
	09:45~09:55	Дурсгалын зураг авахуулах	
	09:55~10:20	Холбооны Хэрэг эрхлэх газрын ажлын тайлан, салбар хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар хийсэн ажлын тайлан	
	10:20~11:00	Орон нутгуудын илтгэл	
	11:00~11:20	Coffee Break	
	11:20~12:30	Хэлэлцүүлэг(I) Гишүүний татвар төлөх журам нэвтрүүлэх - Улс бүрээс санал хэлэх, хэлэлцүүлэг, асуулт хариулт	
	12:30~14:00	Өдрийн хоол	Буудлын 6 давхарт, Rilla Rose танхим
	14:00~15:00	Хэлэлцүүлэг(II) Холбооны үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах - Улс бүрээс санал хэлэх, хэлэлцүүлэг, асуулт хариулт	Буудлын 6 давхарт, Patio танхим
	15:00~15:30	Поско төмөрлөгийн үйлдвэр рүү хөдлөх	автобусаар
	15:30~17:00	Поско төмөрлөгийн үйлдвэр үзэх	
	17:00~17:30	Буудал руу хөдлөх	автобусаар
	17:30~19:00	Амралт	
	19:00~21:00	Хүлээн авалт	Буудлын 6 давхарт, patio танхим
	21:00~	Чөлөөт цаг	
4.29	07:00~09:00	Өглөөний хоол, буудлаас гарах	Буудлын хоол иднэ
	09:00~09:30	Кёنجү хот руу хөдлөх	автобусаар
	09:30~11:30	Яндун тосгон үзэх	Дэлхийн соёлын өвд бүртгэлтэй
	11:30~12:00	Хоолны газар руу хөдлөх	автобусаар
	12:00~13:00	Өдрийн хоол	Пухан хотын төвд
	13:30~	Зочдыг үдэх	BEST WESTERN Pohang Hotel



□Суух дараалал

анонс

□ Орлогч дарга

□ Ерөнхий нарийн
бичгийн дарга

- ☐ Хэйлонжан муж □
- ☐ Хубэй муж □
- ☐ Хунан муж □
- ☐ Жилинь муж □
- ☐ Нинсягийн хотон үндэстний ӨЗО □
- ☐ Шаньдун муж □
- ☐ Ганьсу муж*Ажиллагч статустай □
- ☐ Өвөрмонголын ӨЗО*Ажиллагч статустай □
- ☐ Тояама муж □
- ☐ Хёго муж □
- ☐ Тоттори муж □
- ☐ Шиманэ муж □
- ☐ Пусан хот □
- ☐ Дэгү хот □
- ☐ Инчон хот □
- ☐ Дэжон хот □
- ☐ Ульсан хот □
- ☐ Сэжун хот □

- ☐ Тувагийн БНУ
- ☐ Иркутск муж
- ☐ Улаанбаатар хот
- ☐ Хэнтий аймаг
- ☐ Хөвсгөл аймаг
- ☐ Ховд аймаг
- ☐ Төв аймаг
- ☐ Өмнөговь аймаг
- ☐ Өвөрхангай аймаг
- ☐ Орхон аймаг
- ☐ Завхан аймаг
- ☐ Дорноговь аймаг
- ☐ Говьсүмбэр аймаг
- ☐ Говь Алтай аймаг
- ☐ Жэжү муж
- ☐ Кёнсаннам муж
- ☐ Кёнсанбүг муж
- ☐ Холбооны Хэрэг рхлгх газар

□ Кёнги муж

□ Чүнчонбүг муж

□ Чүнчоннам муж

□ Жолланам муж

Орох хаалга

Орчуулагчийн бүхээг




www.neargov.org

Нэг Зүүн хойд Ази, хамтын хөгжлийг манлайлагч- NEAR
One Northeast Asia, NEAR leading co-prosperity

NEAR Холбооны Хэрэг эрхлэх газрын ажлын тайлан





I. ЗХАНЗХ(NEAR)-ны өнөөгийн байдал





NEAR
GOV
Secretariat

Түүхэн замнал

History of NEAR

- 1993 ~ 1995 : 1-3-р хурал, 4 улсын орон нутаг өрөлцсөн.
- 1996. 9 : БНСУ-ын Кёнсанбүг мужид болсон анхдугаар Бүгд хуралд 4 улсын 29 орон нутаг оролцож, Холбоог анх байгуулсан.
- 2004. 9 : БНХАУ-ын Хэйлонжан мужид болсон 5-р Бүгд хурлаар Холбооны Байнгын Хэрэг эрхлэх газрыг Кёнсанбүг мужид байгуулахаар шийдвэрлэсэн.
- 2008. 9 : БНХАУ-ын Шаньдун мужид болсон Холбооны 7-р Бүгд хурал болсон. Холбооны гишүүн орон нутгийн тоо 6 улсын 69 орон нутаг болтол өргөжсөн. Холбооны Хэрэг эрхлэх газрыг Кёнсанбүг мужид үргэлжлүүлэн байршуулах болсон.
- 2010.10 : БНСУ-ын Кёнги мужид болсон Холбооны 8-р Бүгд хурал болж өнгөрсөн. Холбооны гишүүн орон нутгийн тоо 6 улсын 70 гишүүн орон нутаг болтол өргөжсөн.
- 2012. 7 : БНХАУ-ын Ниншягийн хотон үндэсний ӨЗО-д болсон Холбооны 9-р Бүгд хурлаар Холбооны Хэрэг эрхлэх газрыг Кёнсанбүг мужид удаан хугацаанд байршуулахаар шийдвэрлэсэн. Холбоонд БНСУ-ын Сэжун хот гишүүнээр элсэснээр гишүүн орон нутгийн тоо 71 болж өргөжсөн.
- 2014.10 : БНСУ-ын Жолланам мужид болсон 10-р Бүгд хурал болсон. Гишүүн орон нутгийн тоо 73 болж өргөжсөн.

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA



NEAR
GOV
Secretariat

Холбооны үе үеийн тэргүүлэгч орон нутаг

Former Chairs of NEAR

1.	Кенсанбүт муж, БНСУ/ 1996-1998
2.	Тояама муж, Япон улс/1998-2000
3.	Хёго муж, Япон улс/ 2000-2002
4.	Хабаровск хязгаар, ОХУ/ 2002
5.	Хэйлонжан муж, БНХАУ/ 2002-2004
6.	Пусан хот, БНСУ/ 2004-2006
7.	Шаньдун муж, БНХАУ/ 2006-2008
8.	Кёнгин муж, БНСУ/ 2008-2010
9.	Нинсягийн хотондустний ёзо, БНХАУ/ 2010-2012
10.	Жолтанам муж, БНСУ, 2012-2014
11.	Иркутск муж, ОХУ/ 2014-2016

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

5

NEAR
GOV
Secretariat

Холбооны бүтэц, зохион байгуулалт

Бүгд хурал, Ажлын хэсгийн хорооны хурал, Холбооны Хэрэг эрхлэх газар

Бүгд хурал

Холбооны Хэрэг эрхлэх газар

Ажлын хэсгийн хороо

Салбар хороод

Эдийн засаг, хүмүүнлэгийн харицгаа

Байгаль орчин

Болговсрол, соёлын харицгаа

Тамшгаас сэргийлэх

Хийлийн хамтын ажиллагаа

Шинжлэх ухаан, технологи

Аялал жуулчлал

Дэглэй загварын аж үйлдвэр

Эрчим хүч, уур амьсгал өөрчлөлт

Хүүхдэд эмэгтэйчүүд

Эрдэс баялаг, нөөц боловсруулалт, зохицуулалт

Енэ эмэгтэй аж үйлдвэр

Газар тариалан

Биеийн тамир

Кенсан бүт муж

Тояама муж

Шимао муж

Хёго муж

Иркутск муж

Кёнгин муж

Хэнан муж

Шаньдун муж

Дэгү хот

Дорнод аймаг

Магадан муж

Чунчон бүт муж

Жолтанам муж

Сахагийн БНУ

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

6



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

Гишүүн орон нутгууд (6 улсын 73 орон нутаг, ажиглагч 7 орон нутаг)



БНХАУ
(7)

Хэйлонжан муж, Хэнан муж, Хубэй муж
Хунан муж, Нинсягийн хотон үндэстний ӨЗО, Шаньдун муж, Жилинь муж
*6 ажиглагч орон нутаг(Ляонин муж, Шаньси муж, Шааньси муж, Тяньжин хот, Ганьсу муж, Өвөрмонголын ӨЗО)

Япон улс(10)

Аомори муж, Ямагата муж, Нигатам муж, Тояама муж, Ишикава муж, Фүкүй муж, Киото муж, Хёго муж, Тоттори муж, Шиманэ муж
*1 ажиглагч (Ямагучи муж)

БНСУ(16)

Пусан хот, Дэгү хот, Дэжон хот, Инчон хот, Гуанжү хот, Ульсан хот, Сэжун хот, Кёнги муж, Канвон муж, Чүнчонбүт муж, Чүнчоннам муж, Жоллабүт муж, Жолланам муж, Кёнсанбүт муж, Кёнсаннам муж, Жэжү муж

7



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

Гишүүн орон нутгууд (6 улсын 73 орон нутаг, ажиглагч 7 орон нутаг)



БНАСАУ(2)

Хамгёнбүт муж, Насон хот

Монгол улс(22)

Архангай аймаг, Баянхонгор аймаг, Баянөлгий аймаг, Булган аймаг, Говь-Алтай аймаг, Говьсүмбэр аймаг, Дархан уул аймаг, Дорнод аймаг, Дундговь аймаг, Завхан аймаг, Орхон аймаг, Өвөрхангай аймаг, Өмнөговь аймаг, Сүхбаатар аймаг, Сэлэнгэ аймаг, төв аймаг, Увс аймаг, Ховд аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймаг, Улаанбаатар хот

ОХУ(16)

Буриадын БНУ, Сахагийн БНУ, Тувагийн БНУ, Алтайн хязгаар, Забайкаль хязгаар, Красноярск хязгаар, Иркутск муж, Амур муж, Приморийн хязгаар, Камчатк муж, Магадан муж, Сахалин муж, Томск муж, Кемеровск муж

8

II. NEAR Холбооны өнөөгийн байдал



Үүсгэн байгуулагдсан

- Байгуулагдсан : 2005. 5. 2
- Байршил : БНСУ-ын Кёнсанбүг мужийн Пухан хот(Пухан Техно парк, төв байр 3 давхарт)

NEAR
GOV
Secretariat



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA



NEAR
GOV
Secretariat

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

Бүтэц зохион байгуулалт, үүрэг

● Бүтэц зохион байгуулалт

- Ерөнхий нарийн бичгийн дарга, орлогч дарга, 2 хэлтэс(Төлөвлөлт, олон нийттэй харилцах хэлтэс, Олон улс, хамтын ажиллагааны хэлтэс) : 19 ажилтан
- Ерөнхий нарийн бичгийн дарга, мэргэжилтэн 9, Кёнсанбүг мужийн захиргааны албан хаагч 5, гадаадын төрийн албан хаагч 4

● Ч и г ү ү р э г

- Бүгд хурал, Ажлын хорооны шийдвэрийг хэрэгжүүлнэ
- Гишүүн орон нутгуудийн харилцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.
- Холбооны гурт удаан хугацааны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулна.
- Гишүүн орон нутгууд хооронд харилцааныг үүр болно.
- Мэдээ материалд анализ хийх болон Холбооны хүрээнд мэдээллээр хангана

11



NEAR
GOV
Secretariat

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

2016 оны төсөв

- Төсөв : 1.5 тэрбум вон

Үүнд Кёнсанбүг муж 1 тэрбум 50 сая, Пухан хот 450 сая воны төсөв гаргадаг.

- Төсвийн зардал : 1.5 тэрбум вон
- Ажилчдийн цалин 567 сая вон(38%), үйл ажиллагааны зардал 546 сая вон(36%), хөтөлбөр, арга хэмжээний зардал 387 сая вон(26%)


※ Бүгд хурал болон Холбоо байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээнд төсвийн дэмжлэг үзүүлнэ(80 сая вон), олон улсын форум(130 сая вон)

Орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал (70 сая вон), Зүүн хойд Азийн залуу удирдагчдийн форум(100 сая вон), хүүхэд сурагчдад зориулсан эссэ бичлэгийн уралдаан(7 сая вон)

12



III. 2015 онд хийсэн ажлууд



1. Холбооны Ажлын хэсгийн хорооны 10-р хурал зохион байгуулсан

Хэзээ, хаана : 2015.10.13-10.16, ОХУ-ын Иркутск муж
Оролцсон : 5 улсын 23 орон нутгийн 80 оролцогч
Агуулга : Холбооны Үндсэн дүрэм, гишүүний хураамжийн журмийн төслийн санал, салбар хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх арга замын талаар хэлэлцсэн.
2018 онд Бүгд хурал зохиох газрын хүсэлтийг авсан.





2. Салбар хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн

- 2015. 3 ~ 10 сар, 6 салбар хороо
- Гамшгаас сэргийлэх, Боловсрол, соёлын харилцаа, Эдийн засаг хүмүүнлэгийн харилцаа, Газар тариалан, Далай загасны аж үйлдвэр, Байгаль орчин
- Салбар хороодын үйл ажиллагааны талаарх судалгааны тайланг хийж, салбар хорооды бүрээр зохицуулалт хийх талаар санал гаргасан.

15



3. NEAR 2015-Олон улсын форум зохиосон

- Хэзээ, хаана : 2015. 11. 18~11. 20, БНСУ-ын Сөүл хот)
- Оролцсон : 5 улсын 25 орон нутгийн 200 оролцогч
- Агуулга
- Зүүн хойд Азийн гамшгийн чиглэлээр хэлэлцэх
- Илтгэл, хэлэлцүүлэг

16

4. Дунд, ахлах сургуулийн сурагчдад зориулсан эссэ бичлэгийн 3-р уралдаан

Оролцсон : Гишүүн орон нутгуудын дунд, ахлах ангийн сурагчид

• Зорилго : Сурагчдийн Зүүн хойд Азийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

• Шагнал : 6 (Тэргүүн байр 1, дэд байр 5)

※ Шалгаруулалтад ирсэн бүтээл: 56 (Хятад 2, Япон 6, Солонгос 25, Монгол 1, Орос 22)

17



5. NEAR Холбооны танилцуулга, сурталчилгааны материал эмхлэн гаргасан.

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

NEAR сэтгүүл



• Жилд 6 удаа (2 сарт тутамд)

• Хэвлэсэн тоо : 11 950 ширхэг

• Гишүүн орон нутаг, холбогдох байгууллагуудад тараадаг

2015 оны тайлан



• Жилд 1 удаа гаргадаг

• Гишүүн орон нутаг, холбогдох байгууллагуудад тараадаг

NEAR вэбсайт



• 6 хэлээр гаргадаг

• Холбооны харилцаа, хамтын ажиллагаа, Хэрэгэрхлэх газрын мэдээ, хэрэгжүүлж буй ажил зэргийн талаар мэдээлдэг.

18



NEAR
G O V
Secretariat

19

6. Холбоонд шинээр гишүүн элссэн

- БНХАУ 'Шааньси муж(陕西, Shaanxi)', гишүүнээр элсэх хүсэлтийг Холбооны Хэрэг эрхлэх газарт тавьсан(2015. 12 сар)

7. Гадаадын төрийн албан хаагчдийг Хэрэг эрхлэх газарт төлөөлөгчөөр ажиллуулж байна(11 дэх жилдээ)

- 2006 оны 3 сараас Хятад, Япон, Монгол, Оросоос 1 төрийн албан хаагч ажиллах болсон.
- Тухайн орны хэлний мэргэжилтэний хамтаар нэг баг болон ажилладаг.

CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

IV. 2016 оны ажлын төлөвлөгөө







NEAR
GOV
Secretariat

Голүйл ажиллагаа

- NEAR Холбооны 11-р Бүгд хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
 - Хэзээ, хаана : 2016.9.27-29, ОХУ-ын Иркутск муж
 - Агуулга : Гишүүний татвар төлөх журмийг нэвтрүүлэх, сурвалжлагч гишүүний тогтолцоо, Холбооны Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэх шийдвэрлэх, дараагийн Бүгд хурал зохиох орон нутгийг сонгох, Холбоо байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг хавсран зохион байгуулна.
- “NEAR 2016” Олон улсын форум зохионо
 - Хэзээ : 2016 оны 11 сард
 - Зохион байгуулагч : Холбооны Хэрэг эрхлэх газар
 - Хамтран зохион байгуулагч : Их сургууль, судалгааны газар
 - Агуулга : Зүүн хойд Азийн орон нутаг хоорондын хамтын ажиллагаа, хамтын хөгжлийн арга зам
- ※Форумын сэдвийг сонгохдоо гишүүн орон нутгуудын саналыг авна.



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

21



NEAR
GOV
Secretariat

Гол үйл ажиллагаа

History of NEAR

- “Зүүн хойд Азийн залуу удирдагч 2016” форум зохион байгуулна.
 - Хэзээ : 2016. 8. 7-8. 12
 - Сэдэв : Зүүн хойд Азийн ирээдүй
- : Би, бид
 - Хаана : БНСУ-ын Кёнсанбүг муж дахь их сургууль(Кёнжү хот дахь Дунгүг их сургууль)
 - Оролцох хүрээ : Их дээд сургуулийн оюутан, залуус
 - Оролцогчдийн зардлыг зохион байгуулагч тал хариуцах : Байр, хоол, унаа
- NEAR эсээ бичлэгийн 4-р уралдаан
 - Оролцох хүрээ : Гишүүн орон нутгийн хүүхэд залуучууд
 - Сэдэв : Зүүн хойд Азийн хамтын хөгжлийн арга зам
 - Ангилал : эсээ, гар зураг, зурагт хуудас/постер
 - Шагнал : 12 байр. Ангилал бүрээр тэргүүн байр 1, дэд байр 2, тусгай байр 3/Оролцсон улс бүрээс тус бүр 1
- ※ Уралдаанд материалаа ирүүлсэн бүх оролцогчдод бэлэг дурсгалын зүйл бэлэглэнэ.



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

22



CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

Гол үйл ажиллагаа

History of NEAR

NEAR
GOV
Secretariat

- “NEAR 2016” оны тайлан гаргана
 - Хэзээ : 2016. 11-2017. 1
 - Монгол, орос, хятад, япон, солонгос, англи 6 хэлээр хэвлэн гаргана
 - Холбооны гишүүн орон нутаг, холбогдох байгууллага, олон улсын байгууллагуудад тараана.
 - Гол агуулга
 - ① Бүтд хурал, Олон улсын форум, Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Салбар хороодын үйл ажиллагаа
 - ② Холбооны Хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлсэн хөтөлбөр зэрэг Холбооны нийт үйл ажиллагаа
- NEAR сэтгүүл гаргана
 - Хэзээ : 2016. 1 ~ 12 сар
 - Хэл : монгол, орос, хятад, япон, солонгос, англи 6 хэлээр
 - Хэдэн удаа : Жилд 6 удаа орон нутгууд руу шуудангаар явуулдаг(Энэ оны 6 сараас мэйлээр давхар явуулдаг болно)
 - Тараах газар: Гишүүн орон нутаг, Олон улсын байгууллага, холбогдох байгууллага





CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA

Гол үйл ажиллагаа

NEAR
GOV
Secretariat

- Салбар хороодын хурал зохиоход дэмжлэг үзүүлнэ.
 - 2016 онд зохиогдох салбар хороодын хурал

	Хороо	Харнуцсан орон нутаг	Болох хугацаа
1	Гамшгаас сэргийлэх хороо	Хёго муж/Япон улс	3. 7 ~ 3. 10
2	Эрдэс баялаг, нөөц зохицуулалт, боловсруулалтын хороо	Магадан муж/ОХУ	7. 15 ~ 7. 17(төлөвлөж буй)
3	Соёл, боловсролын харилцааны хороо	Шиманэ муж/Япон улс	8. 19 ~ 8. 24

- NEAR Холбоо ICLEI байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулна.
 - ICLEI : Орон нутгуудын тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын байгууллага
 - 2015. 5 : ICLEI- Солонгос дахь салбар төвийн удирдлагуудтай уулзаж хэлэлцсэн.
 - 2015. 6 : ICLEI салбар төвтэй санамж бичиг байгуулах талаар хэлэлцсэн.
 - 2016. 2 : Санамж бичиг байгуулахтай холбогдуулан гишүүн орон нутгуудаас санал авсан.
 - ※ ICLEI : Тогтвортой хөгжлийн төлөөх орон нутгийн захиргаадыг айгууллага
 - 1990 онд байгуулагдсан, 86 улсын 1000 орон нутаг гишүүнээр элссэн.





CHINA
JAPAN
KOREA
DPRK
MONGOLIA
RUSSIA



Салбар хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар хийсэн ажлын тайлан

NEAR Холбооны Хэрэг эрхлэх газар



Ажлын тойм

- Холбооны Ажлын хэсгийн хорооны 10-р хурал(2015.10.14)-аар салбар хорооны үйл ажиллагааг зохицуулах, идэвхжүүлэх талаар хэлэлцсэний дагуу Холбооны Хэрэг эрхлэх газраас дараах үйл ажиллагааг явуулсан.
- Хороог ажиллуулдаг орон нутгуудын дунд санал асуулга явуулсан.
.Хэзээ : 2016. 1. 11 -2 сар
.Хамрагдсан : 6 орон нутаг (* Сүүлийн 3 жилд үйл ажиллагаа явуулаагүй)
. Агуулга : Салбар хороодын үйл ажиллагаатай холбоотой санал асуулга (Хороог хэвээр байлгах, өөр бусад хороодтой хамтарч үйл ажиллагаа явуулах эсэх, хороог өөр орон нутагт шилжүүлэх, татан буулгах эсэх)
. Санал асуулгад хариу ирүүлсэн : 5 орон нутаг (Санал асуулгын ирц 83%)



Салбар хороодоос ирүүлсэн хариу

но.	Орон нутгийн нэр	Хариуцсан хороо	Хороог ажиллуулах эсэх	
1	Хэнан муж	Аялал жуулчлал	Хороог хэвээр байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулна
2	Дэгү хот	Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт		
3	Кёнгү муж	Шинжлэх ухаан, технологи	Хороог хэвээр байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулна
4	Сахагийн БНУ	Биеийн тамир	Хороог хэвээр байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулна
5	Иркутск муж	Хилийн хамтын ажиллагаа	Хороог өөр орон нутагт шилжүүлэх	Оросын орон нутагт
6	Дорнод аймаг	Хүүхэд эмэгтэйчүүд	Хариу ирүүлээгүй	

※ Бусад санал

- Салбар хорооны хурал арга хэмжээг зохион байгуулах тул цаг хугацаа олгоно уу. Гэхдээ хороог шилжүүлэн авах хүсэлтэй орон нутаг байвал мэдэгдэнэ үү /Кёнгү муж/
- Хилийн хамтын ажиллагааны хороог хил орчмийн орон нутаг шилжүүлэн авч ажиллуулах нь зүйтэй/Иркутск муж /
- Аялал жуулчлалын салбар хорооны хурлыг ‘Ази номхон далайн аялал жуулчлалын нийгэмлэгийн судалгааны аялал болон хариуцлагатай аялалын чуулган болон үзэсгэлэн’-тэй хавсарч зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд одоо Лүоян хотын захиргаатай энэ талаар хэлэлцэж буй /Хэнан муж/



■ Цаашдын төлөвлөгөө

1. Салбар хороог зохицуулах төлөвлөгөө

	Салбар хороод		Холбооны Хэрэг эрхлэх газрын санал	
но.	Орон нутгийн нэр	Хариуцсан хороо	Хороог хэвээр нь байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулах
1	Хэнан муж	Аялал жуулчлал	Өөр орон нутагт шилжүүлнэ	Холбооны аль нэг гишүүн орон нутагт
2	Дэгү хот	Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт	Холбоог хэвээр байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулах
3	Кёнги муж	Шинжлэх ухаан, технологи	Холбоог хэвээр байлгана	2017 онд арга хэмжээ зохион байгуулах
5	Иркутск муж	Хилийн хамтын ажиллагаа	Өөр орон нутагт шилжүүлнэ	Оросын гишүүн орон нутаг
6	Дорнод аймаг	Хүүхэд эмэгтэйчүүд	Өөр орон нутагт шилжүүлнэ	Холбооны аль нэг гишүүн орон нутагт

※ Хэсэгчилсэн төлөвлөгөө

- Холбооны гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал дууссаны дараа дээрх 6 хороог хариуцсан орон нутгуудад төлөвлөгөөг явуулна /5 сард/
- Эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийн хороо, Хүүхэд эмэгтэйчүүдийн хороог зохицуулах, ажиллуулах орон нутгийг бүртгэнэ /6 сард/
- Хороог шилжүүлэн авах хүсэлтэй орон нутгийг бүртгэнэ*/7-8 сард/

※ Шинээр хорооны зохицуулагч болох буюу хороог шилжүүлэн авах хугацааг энэ жилийн Бүгд хурал буюу 9 сараас өмнө хороог шилжүүлэн авах үйл ажиллагааг дуусгавар болгохоор төлөвлөж байна..

2. Бодит харилцааг явуулах арга замыг эрэлхийлнэ.

- Хурлын агуулга/хөтөлбөр/-т бодит харилцаа, хамтын ажиллагааг явуулах чиглэлийг тусгана.
- Хуралд оролцогчдийн хүрээг өргөжүүлэх

- Төрийн албан хаагчаас гадна холбогдох салбарын компани, их дээд сургууль, судалгааны байгууллагын төлөөллийг орлоцуулах зэргээр бодит харилцаа хамтын ажиллагааны боломжийг хангана.

Жишээ 1. Аялал жуулчлалын хороо : Хорооны арга хэмжээнд аялал жуулчлалын компани, хэвлэл мэдээллийн байгууллага, аялал жуулчлалын нийгэмлэгийн төлөөлөл зэргийг урин оролцуулж, бүсийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, харилцаа хамтын ажиллагааны боломжийг олгоно.

Жишээ 2. Газар тариалангийн хороо : Органик газар тариалан, газар тариалангийн технологийн төвийн мэргэжилтэн, компаний төлөөлөл зэргийг урин оролцуулж, газар тариалангийн салбарын талаар санал бодол туршлага солилцох боломжийг олгоно.

- Цаашид бодитой, үр дүнтэй үйл ажиллагаа явуулж буй салбар хороонд санхүүгийн дэмжлэг олгох арга замыг идэвхтэй судалж үзнэ /Гишүүний татварыг үйл ажиллагаанд зарцуулах талаар судлах гм/



www.neargov.org

Нэг Зүүн хойд Ази, хамтын хөгжлийг манлайлагч- NEAR
One Northeast Asia, NEAR leading co-prosperity

Гишүүн орон нутгуудын ИЛТГЭЛ

○ Япон улс

- Тояама муж (Байгаль орчны хорооны тайлан)
- Хёго муж (Гамшгаас сэргийлэх хорооны тайлан)
- Шиманэ муж (Боловсрол,соёлын харилцааны хорооны тайлан)

○ БНСУ

- Дэжон хот (Дэжон хотын танилцуулга)
- Жолланам муж (Дэлхийн байгаль орчны дизайны үзэсгэлэн 2016-танилцуулга)

○ ОХУ

- Иркутск муж (Иркутск мужид хөрөнгө оруулалт хийхийн давуу талууд, боломж)





Байгаль орчны хорооны тайлан

Япон улсын Тояама муж

1. Хурлын тухай

Байгаль орчны хорооны 12-р хурал 2015 оны 11 сарын 11-ний өдөр Тояама мужийн Тояама хотноо болсон. Хуралд 4 улсын 6 орон нутгаас оролцсон. Хурлаар хорооны үйл ажиллагааны тайланг танилцуулсан бөгөөд 2016 онд явуулах төслийн санал авч, 2015-2016 онд хороог хариуцан ажиллуулах зохицуулагчаар Тояама муж сонгогдсон.

2. Төслийн хэрэгжилтийн байдал

2015 оны 4 сараас 2016 оны 3 сар хүртэл дараах төслийг явуулсан. Төслийн талаарх мэдээллийг http://www.npec.or.jp/northeast_asia сайтад байршуулсан.

(1) Зүүн хойд Азийн бүсийн байгаль орчинтой танилцах хөтөлбөр

(Төслийн санаачлагч : Тояама муж)

a. Хугацаа : 2015 оны 8 сарын 19-20-ний өдрүүд

b. Хаана : Тояама мужийн Үцү хот, Гүрүбэ хот

c. Оролцсон : БНСУ, БНХАУ, ОХУ, Япон улсын дунд, ахлах сургуулийн 63 сурагч

d. Агуулга : Хуралд оролцогч орон нутгуудийн илтгэл, далайн хог хаягдлын судалгаа, цэвэрлэгээ, хог хаягдлыг ашиглан бүтээл хийх. Байгаль орчныг хамгаалах талаарх ойлголтыг нэмэгдүүлж “Тояамагийн байгаль орчны тунхаг”-ыг зарласан.

(2) Далайн хог хаягдлын судалгаа хийх болон хог хаягдлаар урлагийн бүтээл хийх

a. Хугацаа : 2015 оны намар/хог хаягдлын судалгаа, урлагийн бүтээл хийх/жилийн турш/

b. Хаана : Зүүн хойд Азийн бүсийн далайн эрэг

c. Оролцсон улс : Солонгос, Япон, Орос 3 улсын 15 орон нутаг

d. Агуулга : Далайн хог хаягдлыг судлахын зэрэгцээ хог хаяхгүй байх, далайн орчин, байгаль хамгаалах ухамсрыг нэмэгдүүлэхийн тулд нутгийн иргэд, хүүхдүүдийг хамруулан далайн хог хаягдлын төрөл бүрээр түүн ангилан ялгаж, шинжлэх судалгааг хийсэн. Дараагаар нь түүж цуглуулсан хог хаягдлыг ашиглан урлагийн бүтээл хийсэн.

(3) Зүүн хойд Азийн байгаль орчны постерийн үзэсгэлэн

a. Хугацаа : 2015 оны 10-11 сар

b. Хаана : Япон улсын Тояама муж

c. Оролцсон улс : Солонгос, Япон, Хятад, Орос 4 улсын 7 орон нутаг

d. Агуулга : Зүүн хойд Азийн хүүхдүүдийн дунд байгаль орчныг хамгаалъя сэдвээр постерийн уралдаан зарлаж, уралдаанд ирүүлсэн бүтээлээр үзэсгэлэн гаргасан.

3. Цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөө

2016 онд Зүүн хойд Азийн байгаль орчинтой танилцах хөтөлбөр, далайн хог хаягдлыг түүн судлах болон хог хаягдлаар урлагийн бүтээл хийх, Зүүн хойд Азийн байгаль орчны постерийн үзэсгэлэн, далайн амьд биетийн судалгааг явуулна. 2017 онд Байгаль орчны хорооны 13 дахь удаагийн хурлыг Тояама мужид зохион байгуулна.

4. Бусад

2016 оны 5 сард Японд удсал зохиогдох “Ишэшима-Дээд хэмжээний уулзалт”-ыг угтаж 5 сарын 15-16-ны өдрүүдэд “G7-Тояама мужийн байгаль орчны яамдын сайд нарын хурал” болно. Үүний зэрэгцээ “Зүүн хойд Азийн орон нутгуудын байгаль орчны форум” 5 сарын 23-24-ний өдрүүдэд болно.



Гамшгаас сэргийлэх хорооны танилцуулга

【Гамшгаас сэргийлэх хорооны 14-р хурлын тайлан, дараагийн хурлын төлөвлөгөө】

2016. 4. 28

Хёго мужийн захиргааны Олон улстай харилцах хэлтсийн дарга
Ишида Кацнури

Hyogo Prefectural Government



1. Ханшин Аважид болсон хүчтэй газар хөдлөлт



Ханшиний хурдны зам, Кобэгийн чиглэл



Газар хөдлөлтийн далайц

【Хэзээ】 1995. 1.17, өглөөний 5 цаг 46 минут
【Эпицентр】 Аважи арлын хойд хэсэгт 16km-ийн гүнд
【Балл】 M7.3, эхний чигирхийлэл 7 балл

Хохирлын далайц

【Хохирол】
Нас барсан: 6402
Шууд хохирлын дүн: 10 триллион иен
Эвдэж сүйдсэн сууц: 104004(182,751 өрх)
Оронгэргүй болсон: 316,678хүн(1995. 1. 23)

Газар хөдлөлтийн дараа(Кобэ хотын Нагата дүүрэг)



2. Гамшгаас сэргийлэх хорооны 14-р хурал

Хёго мужийн Гамшгаас сэргийлэх төв



Оролцсон

3 улсын 18 орон нутгийн 36 оролцогч
 Жилинь муж, Шаньдун муж, Хунан муж, Ниншиягийн хотон үндэстний ӨЗО,
 Жолланам муж, Чүнчонбүг муж, Ульсан хот, Кенсанбүг муж,
 Кенсаннам муж, Пусан хот, Өвөрхангай аймаг, Дундговь аймаг,
 Булган аймаг, Завхан аймаг, Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймаг, Хөвсгөл аймаг
 NEAR Холбооны Хэрэгэрхлэх газар

Гол хөтөлбөр

3.7 Хүлээн авалт

3.8

- ① Хүн ба гамшгаас сэргийлэх ирээдүйн төвтэй танилцах
- ② Илтгэл "Хёго мужийн гамшгаас сэргийлэх бодлого"
- ③ Азийн гамшгаас сэргийлэх төв ийн удирдлагуудтай санал бодол солилцох
- ④ "Салаа зам" гамшигтай холбогдох төсөөллийн тоглоом

3.9

Аялал(Хёго мужийн гамшгаас сэргийлэх төв, Гамшгийн үеийн эмчилгээний төв

Хёго мужийн гамшгийн үеийн эмчилгээний төв



3. Дараагийн хурлын төлөвлөгөө

(1) Хугацаа: 2017 оны 3 сард

(2) Сэдэв: Орон нутгийн гамшгийн аюулыг бууруулах арга зам

(3) Хаана: Хёго мужийн Кобэ хот

Газар хөдлөлтөөс үүдсэн туршлага, сургамжийг түгээх "Хүн ба Гамшгаас сэргийлэх ирээдүйн төв"





**HYOGO
PREFECTURE**



Акаши гүүр, Сунбүний дурсгалын музей




Арима халуун рашаан



YHC)
HYOGO
PREFECTURE



Кобэгийн үхрийн мах



Кобэгийн амтан



Далайн бүтээгдэхүүн: хавч, загас



Япон архи (Японы дотоодод архи үйлдвэрлэлээр тэргүүлдэг)



Баярлалаа.



Хёго мужийн бэлгэдэл 「Хабатан」

“Зүүн хойд Азийн харилцааны жигүүр 2015” арга хэмжээний тойм

2015 оны 8 дугаар сарын 1-нээс 6-ны өдрүүдэд Хятад, Солонгос, Орос улсын залуучууд Японы соёл, ард түмний аж амьдрал, (энэ хугацаанд япон айлд байрласан) зан заншилтай танилцахаар Шиманэ мужид зочиллоо. Хөтөлбөрт хамрагдсан залуучууд мөн энэ хугацаанд “Хүүхэд хүмүүжүүлэх төв”-д зочилсон юм.

Арга хэмжээний сүүлчийн өдөр хөтөлбөрт хамрагдсан залуус тус байгууллагатай танилцсан сэтгэгдлээ хуваалцаж, өөр өөрсдийн орон нутагт хүүхэд хүмүүжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлдэг арга хэмжээг танилцуулсан. Түүнээс гадна энэхүү танилцах аялал, арга хэмжээний тухай болон соёл хоорондын харилцааны тухай санал сэтгэгдлээ солилцсон.

Шиманэ мужийн хариуцан ажилладаг Боловсрол, соёлын харилцааны салбар хороо нь ийнхүү Зүүн хойд Азийн бүсэд залуучуудын солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлснээр найрамдал нөхөрлөлийн шинэ харилцааг бий болгож, гишүүн орон нутгуудын харилцан ойлголцлыг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.

Хөтөлбөрт оролцсон

БНХАУ: Жилин муж, Нинся-Хуйн өөртөө засах орон нутаг-8 хүн

БНСУ: Донгүк Их сургууль, Уйдок их сургууль– 6 хүн

ОХУ: Приморийн хязгаар– 4 хүн

Япон: Шиманэ муж – 6 хүн


«Арга хэмжээний хөтөлбөр, мэдээлэл»

Сар, өдөр	Хөтөлбөр
7.31	Шиманэ мужтай танилцах, солилцооны хөтөлбөрийн агуулгатай танилцах
8.1	Нээлтийн ажиллагаа, мэндчилгээ Япон айлд байрлах
8.2	Япон айлд байрлаж танилцах
8.3	- Хүүхэд хүмүүжлийн төвтэй танилцах (Мацуэ хотын хүүхэд хүмүүжлийг дэмжих төвийг үзэж сонирхох, төрөлт багасаж байгаа тухай сэдвээр лекц) - Японы соёлтой танилцах (амттан бэлтгэх) Оройн хоол, нэгдсэн арга хэмжээ
8.4	- Санал солилцоход бэлтгэх - Санал бодлоо солилцох Үдэлтийн зоог
8.5	Оролцогчид нутаг буцах



Шиманэ мужид болсон “Зүүн хойд Азийн харилцааны жигүүр-2015” арга хэмжээний үеэр

7 сарын 31



«Оролцогчид хоорондоо танилцав»

8 сарын 1-2-ны өдөр



«Шиманэ мужийн Амьдрал, байгаль орчны хэлтсийн даргатай хамт»



«Танилцах уулзалт болон япон айлд зочилсон нь»



«Хятадын Жилинь муж, Нинсягийн хотон үндэстний ӨЗО-ы залуус»



«Солонгосын Донгук их сургууль, Уйдок их сургуулийн залуусын тоглолт»



«Оросын залуусын тоглолт»



«Шиманэ мужийн залуусын тоглолт»

8 сарын 3



«Төрөлт буурч буй тухай сэдвээр лекц»



«Амттан хийж үзэв»



«Санал бодлоо солилцсон нь»

8 сарын 4



«Санал солилцсон нь»

Улс бүрээс ирсэн оролцогчид хүн амын төрөлт буурч, хөгширч байгаа тухай сэдвээр илтгэл тавьж, соёл хоорондын харилцан ойлголцлын тухай санал бодлоо солилцов.



«Үдэлтийн зоог»

Иргэн төвт! Дэжон хот



Иргэн төвт Дэжон хот

Contents


Part I Дэжон хотын танилцуулга

- ◆ Өнөөгийн байдал
- ◆ Дэжон хот байгуулагдсаны 100 жилийн ой, Шинжлэх ухааны хот болж хөгжсөн.

Part II Иргэн төвт Дэжон хот

- ◆ Зорилт
- ◆ Иргэн төвт үйл ажиллагаа
- ◆ Дүгнэлт

Part I Дэжон хотын танилцуулга




Дэжон хотын өнөөгийн байдал

- ◆ Өнөөгийн байдал (2014 оны сүүлийн байдлаар)
- Хүн : 1.540.000 *Солонгост 2-рт орох залуу хот
- Засаг захиргааны нэгж : 5 дүүрэг, 78 хороо
- Төрийн албан хаагч : 7174
- Төсөв 5 триллион 670.7 тэрбум вон
- ДНБ : 32 триллион 200 тэрбум вон (1 хүнд ногдох ДНБ 20 сая 840 мянган вон)
- Аж үйлдвэрийн бүтэц : Үйлчилгээ 81.7%, үйлдвэрлэл 18.2%, газар тариалан 0.1%


Дэжон хот байгуулагдсаны 100 жилийн ой, Шинжлэх ухааны хот болсон.

- ◆ Дэжон хот байгуулагдсаны 100 жилийн ой, Шинжлэх ухааны хот болсон.
- ◆ Дэжон хот өнгөрсөн 100 жилд
- 1914 Дэжон хот байгуулагдсан
- 1974 Дэдог судалгааны цогцолбор байгуулагдсан
- 1993 Дэжон-Дэлхийн экспог амжилттай зохион байгуулсан.
- 1995 Дэжон бие даасан хот байгуулагдсан/
- 1998 Дэлхийн худалдааны байгууллага, дэлхийн гол шинжлэх ухааны хотуудтай харилцаа тогтоосон.
- 2009 Дэжон-Олон улсын сансрын чуулганыг зохион байгуулсан.
- 2012 Дэлхийн тогоочдын ур чадварын тэмцээнийг зохион байгуулсан.
- 2015 Дэлхийн шинжлэх ухааны хотуудын захирагч нарийн хурал, Дэлхийн зөгийн аж ахуйн бага хурал зохион байгуулсан.

Дэжон хот байгуулагдсаны 100 жилийн ой, Шинжлэх ухааны хот болох



Part II Иргэн төвт хот-Дэжон.



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

◆ Зорилт, чиг үүрэг

Иргэд нь аз жаргалтай Дэжонийг бий болгох

Иргэдэд ойр захиргааны үйл ажиллагаагаар нийгмийн итгэлцлийг бий болгох (Чиг үүрэг)

1. Иргэд оролцох тогтолцоог бий болгох

-Иргэдийн гомдол хүсэлтийг цахимаар болон цахим бусаар шийдвэрлэх, төсөв шийдэх, бодлогын талаарх санал зэргийг хотын захирагчид шууд хүргэх системийг нэвтрүүлэх

2. Газар дээрээс нь байдалтай танилцах

- Захиргааны ордоноос газар дээр нь байдалтай танилцах иргэн төвт харилцаа

3. Нийгмийн итгэлцлийг байгуулах системийг бий болгох

- Зөрчилтэй асуудал, үйл ажиллагаанд иргэд биечлэн оролцон оновчтой шийдвэр гаргах системээр дамжуулан иргэдтэй тохиролцоонд хүрэх



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

◆ Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

1 Иргэдийн аз жаргалын хороо

▶ (Хорооны бүрэлдэхүүн) 500 хүн (Иргэдээс бүрдүүлнэ)

(Байгууллагын ажилтан, багш, мэргэжилтэн, оюутан сурагч, гэрийн эзэгтэй, ТББ, нийгмийн эмзэг бүлэг м)

▶ (Хороог ажиллуулах арга) Уулзалт, чөлөөт хэлэлцүүлэг

▶ (Гол чиг үүрэг)

- Хотын захиргааны гол бодлогын талаарх зөрчилдөөнийг зохицуулах болон иргэдтэй тохиролцоонд хүрэх

- Иргэдийн оролцоотой хэлэлцүүлгийн үр дүнг хотын бодлогод тусган шийдвэрлэх систем.



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

2. Хүндэт хотын захирагчийн тогтолцоог нэвтрүүлсэн

► (Хугацаа) 6 сар(Хугацааг сунгахгүй), цалингүй

► (Хүний тоо) 8 чиглэл/чиглэл бүрээр 1 хүн (8)

- Эдийн засаг, аж үйлдвэр, шинжлэх ухаан, аюулгүй байдал, соёл биеийн тамир, эрүүл мэнд нийгэмл халамж, байгаль орчин, барилга, зам тээвэр, сууц,

► (чиг үүрэг) бодлогын санал, иргэдийн оролцоо, газар дээрээс нь иргэдийн саналыг авах

► (Ажлын үр дүн)

- 298 удаагийн үйл ажиллагаа (Хурал, газар дээр нь танилцах, арга хэмжээнд оролцох гм), 93 бодлогын санал авсан.

- Хотын бодлогод тусгасан 69 санал хүсэлт(74%), удаан хугацаанд судлах16(17%), бодлогод тусгаагүй 8(9%), санал хүсэлт



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

3. Иргэний оролцоот төсвийн тогтолцоог ажиллуулах

► (Бүрэлдэхүүн) 69 хүн/ 8 чиглэл (чиглэл бүрээр 8~9 хүн)

► (Үйл ажиллагаа) хурал, салбар хороо, зохион байгуулалтын хороо, төсвийн судалгааны хороо

► (Чиг үүрэг) Төсөв боловсруулахад иргэдийг оролцуулан болон шийдэх

► (2015 оны ажлын үр дүн)

- 147 удаагийн санал, 123-г баталсан

※ Тухайн үеийн төсөв 2 триллион 612 тэрбум 700 сая won / Тусгасан төсөв 1 триллион 338 тэрбум 100 сая won

(Нийт төсвийн 51.21%-г иргэдийн оролцоотойгоор төсөвт тусгасан)



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

4.Иргэдийн дуу хоолойг сонсох

► (Ажиллах хэлбэр) Хотын захиргааны ордны 1давхарт / Өдөр бүр09:00-18:00 цагт

► (Ашиглах хүрээ) Иргэд

► (Ярих хугацаа) 1 хүн 10 минут

► (Агуулга) Хотын захиргааны бодлогын талаар санал тавих, иргэдийн хүсэлт зэрэг чөлөөтэй сэдвээр

► (Хэрхэн оролцох) Системд хувь хүний мэдээллийг оруулсаны дараа чөлөөтэй ярих

► (Хэрхэн илтгэх) Индэрийн өмнө илтгэх(видео бичлэг хийнэ) → бүртгэж авах болон ангилна →

Асуудлыг судалж, газар дээр нь очиж шалгана(Холбогдох хэлтэс) → Хариут өгөх(3 өдрийн дотор)

► (Үр дүн) 70 асуудлыг хүлээн авч шийдвэрлэсэн (2015 оны 5 сар ~ одоогийн байдлаар)



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

5. Хотын захирагчийн ажлын алба явуулын үйл ажиллагаа явуулдаг.

► (Хугацаа) 4 чиглэлээр сард 1 удаа

- Ард иргэдтэй уулзах(Сарын эхний долоо хоногт), дотоод ажилтай танилцах(Сарын 2 дох долоо хоногт)

-Газар дээр нь биечлэн танилцах, сайн дурын үйл ажиллагаа(Сарын гуравдах долоо хоногт), Барилга засварын үйл ажиллагаатай танилцах(Сарын дөрөв дөх долоо хоногт)

► (Үйл ажиллагааны арга) Газар дээр нь танилцах → Санал хүсэлтийг сонсох → Хариуг мэдэгдэх(3 өдрийн дотор)

※ Хотын захиргааны вэбсайтад хэрэгжилтийн байдлыг танилцуулах, санал хүсэлтийг хүлээж авч шийдэх

► (Үр дүн) Жилд 42 удаа явуулын үйл ажиллагаа явуулсан.



Иргэн төвт Дэжон хотоос хэрэгжүүлж буй гол ажил

6. Онлайнаар дамжуулан иргэдийн оролцоотой захиргаа удирдлагын үйл ажиллагааг бодитой болгох

► Онлайн үйл ажиллагаа

- (Хамрагдах хүний тоо) 2,000/ТББ-аас оролцох, онлайнаар нээлттэй шалгаруулдаг

- (Үйл ажиллагаа) Гол үйл ажиллагааны талаар онлайнаар санал асуулга явуулж → Санал асуулгыг дүгнэж агуулгыг бодлогод тусгадаг

► Олон нийтийн сүлжээний хэрэгслээр дамжуулан иргэдтэй харилцах харилцааг идэвхжүүлдэг

- Дэжон хотын захиргаанаас албан ёсоор олон нийтийн сүлжээг ажиллуулдаг : Твиттер, фэйсбүүк, блог гм

※ твиттерт(16,700 хүн), фэйсбүүкт(38,000 хүн),

Блог(Өдөрт дунджаар 3000 гаруй хүн үздэг)

- Ард иргэд хотын бодлого гаргахад оролцох боломжийг нэмэгдүүлэх, харилцах сувгийг олон талын болгодог.

Дүгнэлт

◆ Дүгнэлт

Иргэн төвт, зорилт, асуудлыг голчилсон, газар дээр нь ажилладаг, хамтран ажилладаг, нээлттэй, мэдээллийг хуваалцдаг

Иргэн төвт, зорилт, асуудлыг голчилсон, газар дээр нь ажилладаг, хамтран ажилладаг, нээлттэй, мэдээллийг хуваалцдаг

Good Governance

Баярлалаа.

세상을 바꿀 새로운 삶의 모색

2016 세계 친화경 디자인 박람회

WORLD
ECO-FRIENDLY DESIGN
EXHIBITION, KOREA



2016. 5. 5~29

전남 농업기술원, 빛가람혁신도시 일원



Дэлхийн эко дизайны үзэсгэлэн 2016

I. Үзэсгэлэнгийн тухай

1. Ерөнхий тойм

Болох хугацаа : 2016.5.5-5.29/25 өдөр

Хаана : Нажү хот/Жолланам мужийн газар тариалан технологийн хүрээлэн, Бидгарам инновацийн хот

Зохион байгуулагч : БНСУ-ын Аж үйлдвэр худалдаа нөөцийн яам, Үзэсгэлэн зохион байгуулах хороо

Орох тасалбар : Том хүн 9000/хүүхэд 4000 ※4/30 хүртэл хямдралтай үнээр

Гол агуулга : Үзэсгэлэн, олон улсын симпозиум, мюзикл, танин мэдэхүйн хөтөлбөр, худалдаа



II. Гол хөтөлбөр

Сэдэвт үзэсгэлэн : тусгай сэдэвтэй 7 танхимд гарах үзэсгэлэн

Гадаа үзэсгэлэн : Далайн зам үзэсгэлэн, Далайн зам, Амьсгалагч шоо гм

Соёлын арга хэмжээ : Мюзикл(өдөрт 2 удаа), бөмбөрийн тоглолт, агаарын цэргийн үзүүлэх тоглолт, EBS телевизийн цэцэрлэг хүүхдүүдэд зориулсан арга хэмжээ гм

Эрдэм шинжилгээний арга хэмжээ : “Эко дизайн” олон улсын симпозиум/нийт 5 удаа

			
Далайн зам үзэсгэлэн	Байгалийн будгаар өнгө оруулах сургалт	Хүүхдэд зориулсан павилион	Амьдралын сэдэвт үзэсгэлэн
			
Мюзикл	Бөмбөрийн тоглолт	Олон улсын симпозиум	Агаарын цэргийн тоглолт

※ Лавлах : www.ecodex.or.kr / odamino@korea.kr



Иркутск мужид хөрөнгө оруулалт хийхийн давууталууд, бoлoмжийн тухай

ОХУ-ын Иркутск муж

Өнөөдрийн энэхүү уулзалтанд оролцож буй хэн бүхэнд Иркутск мужийг төлөөлж болон хувиасаа чин сэтгэлийн мэнд дэвшүүлье!

Гурван зууны түүхтэй Иркутск муж нь Орос улсын Ази тив дэхь газар нутгийн төв хэсэгт, Ази-Номхон далайн бүсийн орнуудыг зорих “Торгоны зам” дээр байрласан нь эдийн засаг-газар зүйн хувьд маш тохиромжтой байрлал юм.

Тус муж нь ОХУ-ын Сибирийн тойргийн бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд засаг захиргаа, аж үйлдвэрлэл, соёлын төв нь Эрхүү хот юм. Газар нутгийн хувьд 774 846км² талбай эзэлдэг (энэ нь ОХУ-ын нийт нутгийн 4,6%), нийт 2,418,348 хүн амтай.

Байгалийн баялгийн нөөц, төрлөөрөө ОХУ-ын муж, хотууд дундаа тэргүүлдэг бөгөөд ашигт малтмалын томоохон орд газар, нөөцүүд энэ нутагт төвлөрсөн байдаг. Тухайлбал: улсын нийт алтны нөөцийн - 31%, ой модны - 11%, байгалийн хийн – 8%, нүүрсний – 7%, нефтийн – 3%, гялтгануурын нөөцийн – 80 % нь Иркутск мужийн нутагт бий.

Мод бэлтгэлийн хэмжээгээрээ Орос улсдаа тэргүүлдэг бол Сибирийн тойрогтоо нефть дахин боловсруулалтын хэмжээгээрээ 1 дүгээрт, ашигт малтмалын олборлолтын хэмжээгээрээ 2 дугаарт ордог

Тус мужид аж үйлдвэрлэлийн хүчирхэг суурь бааз бүрэлдэж бий болсон, тухайлбал Орос улсын нийт целлюлозын 57%, поливинилхлоридын 42%, хөнгөн цагааны 35%, цахилгаан эрчим хүчний 27%, мод модон бүтээгдэхүүний 12 %-ийг үйлдвэрлэж байна.

Иркутск муж нь газар зүйн ашигтай байрлал, байгалийн арвин нөөц баялаг, шинжлэл ухааны хөгжил, инноваци, дэд бүтэц болон боловсролын шилдэг байгууллагууд зэргээрээ бусад мужуудаас онцгой ялгардаг. Мужийн цахилгаан эрчим хүчний хангамж нь улсдаа хамгийн өндөрт тооцогддог. Бас өөр нэгэн онцлог бол Иркутск мужид цахилгаан эрчим хүчний хүчдэл хангалттай, үнэ нь маш хямд юм. 1квт цахилгаан эрчим хүчний үнэ: 0.04 \$ (өндөр хүчдэл); 0.06 \$ (нам хүчдэл) байдаг.

Хөрөнгө оруулалтыг тагаж, тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр зорьж буй салбаруудыг слайдад харуулсан байна. Эдгээр салбарыг сонгож авахдаа хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзсэн юм. Тухайлбал Иркутск мужид эртнээс хөгжиж ирсэн уламжлалт салбарууд (төмөрлөг боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр), байгалийн баялгийн арвин баялаг нөөц, тэдгээрийг олборлох гайхам таатай нөхцөл (нефтьгазхимийн үйлдвэрлэл, мод боловсруулах үйлдвэр), өндөр нэмүү өртөг шингээх, кластер бий болгох ирээдүй (нефть газ химийн үйлдвэрлэл, автомашин, эм бэлдмэл, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл), хүн амыг тогтвортой суурьшуулах, хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх (хөдөө аж ахуйн салбар) гэх мэтийг харгалзан үзсэн.

Өндөр нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн, мужийн хөгжлийн түлхүүр болсон хэд хэдэн асуудлыг онцлон хэлж болно. Үүнд: нөөц баялгийн ашиглалтын цар хүрээг өргөтгөх, олборлосон түүхий эдийн боловсруулалтыг сайжруулж, өндөр түвшинд хүргэх, Байгаль нуур орчмын газар нутгийг зүй зохистой ашиглах, шинжлэх ухаанд суурилсан аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг юм. Хөрөнгө оруулалтын төслүүдийг “Нэг цонх”-ны зарчмаар хэрэгжүүлэх зорилгоор “Иркутск мужийн хөгжлийн корпораци”-ийг 2013 онд байгуулсан бөгөөд тус байгууллагыг Иркутск мужийн захиргаанаас удирддаг. Байгууллагын нийт дүрмийн сан нь 52.2 сая ам.доллар бөгөөд мужийн нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх, аж үйлдвэрийн паркууд байгуулах, хөгжүүлэх, нийгэм-эдийн засгийн асуудлуудыг шийдэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгох, сайжруулах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бие дааж явуулах болон хамтран оролцох, мужийн нутагт төр-хувийн хэвшлийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Иркутск мужийн аялал жуулчлалын нөөц бололцоо нэн их. Мужийн нутаг дэвсгэрт дэлхийн хамгийн гүн, цэнгэг уст нуур болох Байгал нуур оршдог. Байгалийн унаган төрх, чанараараа энэ нуур нь Орос улсаас анх удаа ЮНЕСКО-ийн дэлхийн өвд бүртгэгдсэн юм.

Байгаль нуур нь зөвхөн байгалийн үзэсгэлэнт газар төдийгүй энэ нутгийн уугуул буриад түмний зан заншил, уламжлалыг сайтар хадгалж ирсэн, хадны сүг зураг, бөөгийн ёслолын шүлэг бичээсүүд, археологийн дурсгал бүхий Төв Азийн оюуны болон материаллаг соёлын үнэт өв билээ.

Манай муж нь балар эртний үеэс эхлээд, Дорнод сибирьт орос үндэстэн суурьшсан үе, декабристуудын үе, Зөвлөлт засгийн бүтээн байгуулалтын үе гэх мэт олон цаг үеийн түүх-соёлын ул мөрийг хадгалсан үлэмж баялаг өв, нөөц бүхий нутаг. Тус мужид 60 гаруй музей байдгийн дундаас архитектур- угсаатны зүйн «Тальцы» музей болон дэлхийд танигдсан «Кругобайкальская» төмөр зам хэмээх инженер-архитектурын цогцолбор илүү алдартай.

50 гаруй жилийн турш бид дэлхийн бүх л өнцөг булан бүрээс зочид гийгчдийг хүлээн авсаар байна. Энэ хугацаанд аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний соёл, боловсон хүчин болон аялалын маршрутууд хэдийнээ бүрэлдэж бий болжээ.

Байгаль нуурын өмнө хэсэгт аялал жуулчлалыг төрөл бүрээр хөгжүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг байгуулж байна.

Мөн нуурын эрэгт аялал жуулчлал, амралт сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй компаниудад зориулан «Байгалийн үүд» нэртэй аялал-амралтын чиглэлийн эдийн засгийн тусгай бүсийг байгуулсан. Энэхүү эдийн засгийн бүсэд хөрөнгө оруулагчдад зориулсан дараах хууль, эрх зүйн дэмжлэгүүдийг үзүүлнэ. Үүнд:

- Орлогын албан татварын хэмжээг бууруулна. (13,5%),
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвараас 10 жилийн хугацаатай чөлөөлнө.
- Газрын татвараас 5 жилийн хугацаатай чөлөөлнө,
